



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН

БИРЖ-д

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот 17062, Хан-Уул дүүрэг
3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Утас: 70135511
Факс: 70143081, УБ-36 Ш/х №434
И-мэйл: info@gobi.mn Вэб сайт: www.gobi.mn
ҮБД: 9010001061

2020. 04. 02 № 01/278
Танай _____ ны № _____ -д

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Дэлхий нийтэд өндөр хурдацтай тархаж байгаа “COVID-19”-ын цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгах 102 дугаар тоот тогтоолыг Монгол Улсын Засгийн Газар 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан билээ.

Говь ХК Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2020 оны 4 сарын 24-ний өдрийн 10:00 цагт “Corporate Hotel and Convention Centre”-н концертын танхимд зохион байгуулахаар төвлөсөн байсан хэдий ч үүсээд буй нөхцөл байдлын улмаас бид хурлыг зохион байгуулах боломжгүй болоод байгаа юм.

Иймд бид аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны гаргасан зөвлөмж, чиглэлийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2020 оны 4 сарын 24-ний өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

Бид хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хамгаалж, хурлыг цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулахаар хичээн ажиллаж байна.

Хүндэтгэсэн,

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Б. Нарантуяа* Б.НАРАНТУЯА

